

Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны "Булганы Сэргэлт" хөтөлбөрийн 2025 оны эхний хагас жилийн хэрэгжилтийг тооцох жагсаалт

№	/ ТЕЗ / Хөтөлбөрийн нэр	Үр дүн, үндсэн үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин		Зорилтот түвшин	Хэрэгжилт-Хүрсэн түвшин	Хэрэгжилтийн хувь	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл
					он	түвшин					
НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН СЭРГЭЛТ											
Эрүүл мэнд											
1.1	ТЕЗ	Хүн амын эрүүл мэндийн зөв дадал хэвшүүлж, нийгмийн эрүүл мэндийн сэргэлтээр дундаж наслалтыг нэмэгдүүлнэ.	Хүн амын дундаж наслалт	Жилээр	2024	74.37	74.62	Эрүүл мэндийн байгууллагууд иргэдэд эрүүл мэндийн мэдлэг олгох, зөв дадал эзэмшүүлэх, хандага өөрчлөх сургалт, сурталчилгааг тусгай хөтөлбөр, удирдамжийн дагуу зохион байгуулан 8910 хүнийг хамруулсан. Аймгийн НЭ, сум, өрхийн ЭМТ-үүд амбулаторийн үзлэгт 8899, хэвтэн эмчлүүлсэн 3822, урьдчилан сэргийлэх үзлэгт 17507, сургуульд суурилсан эрт илрүүлэг үзлэг, дархлаажуулалтад 3017, насан хүрэгсдийн эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан 2807, нийт 33245 иргэнд эрүүл мэндийн зөвлөгөө өгч, 9068 иргэнтэй эргэх холбоотой ажилласан байна. ЕБС-ийн суралцагчдад хорт зуршлаас сэргийлэх сургалт зохион байгуулан 246 хүүхдийг хамруулж, 2 төрлийн 439 ш гарын авлага олгосон. Эрүүл мэндийн байгууллагууд иргэдийн эрүүл мэндийн мэдлэгийг нэмэгдүүлэх 212 сурталчилгаа, мэдээллийг цахим хуудсан байршуулж, цахим орчноос 42684 хүн мэдээлэл авч үзсэн байна. Аймгийн дүнгээр 2024 оны байдлаар хүн амын дундаж наслалт 75.01 байна.	90		
1.1.1		Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.	Эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалт	Хувь	2024	43.2	50.0	Халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгийг аймгийн НЭ-ийн дэмжих төвөөр 867 иргэн, явуулын баг буюу нарийн мэргэжлийн эмчийн үзлэг оношилгоонд 1904 иргэн, нийт 2807 иргэнийг эрт илрүүлэг үзлэгт хамруулсан. Халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих иргэдийн 47,4%-ийг хамруулж, өмнөх оныхоос 4.2%-иар өссөн байна. Сумдын ЭМТ-үүд элэгний В,С вирус илрүүлэх шинжилгээнд 2100 хүний хамруулан, В вирус илрээгүй иргэдийг В гепатитийн эсрэг сайн дурын дархлаажуулалтын 1, 2, 3-р тунд 2011 хүн тун вакцин хэрэглэсэн байна. ЕБС-ын 6 настнуудыг нүд, шүд, зүрхний эмгэгийг эрт илрүүлэх урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан ажиллаж байна. Сургуульд суурилсан нүдний эрт илрүүлгийн анхан шатны үзлэг бүрэн дуусаж нарийн мэргэжлийн эмчийн үзлэг эхэлсэн. Шүдний эрт илрүүлэг үзлэг 72%-тай, зүрхний үзлэгт 61%-ийн хамралттай байна.	90		
			Сургалтад хамрагдсан иргэд	Тоо	2024	14000	15000	ЭМБ-ууд нэрэмжит сарын аян, тэмдэглэлт өдрүүд, халдварт бус өвчин, ЕБС-иуд суурилсан үзлэг, оношилгоо, дархлаажуулалтаар 8910 хүнд сургалт, сурталчилгааг зохион байгуулж, иргэдэд эрүүл мэндийн мэдлэг олгосон. Эрүүл мэндийн газрын албан ёсны цахим хаяг www.bu.mohs.go.mn болон Эрүүл мэндийн байгууллагуудын цахим нүүр хуудсаар цаг үеийн мэдээ, мэдээллийг түргэн шуурхай, үнэн зөв хүргэх зорилгоор давхардсан тоогоор 212 мэдээллийг цахим хуудсан байршуулж, 42684 хүн цахим хуудсанд хандаж мэдээлэл авсан байна.	90		
			Хорт хавдар өвчний шалтгаант нас баралтын түвшин /10,000 хүн амд ногдох/	Түвшин	2024	14.1	13.1	2025 оны эхний 5 сарын 31-ны өдрийн байдлаар 47 иргэн хорт хавдар (элэг 21, ходоод 7, улаан хоолой 3, бүдүүн гэдэс 3, шулуун гэдэс 1, хойр булчирхай 2, уушги 3, умайн хүзүү 2, өндгөвч 1, бусад 4) өвчний улмаас нас барсан нь 10.000 хүн амд 7.8 промиль байна. Хавдар өвчний шинэ тохиолдол 45. Хавдар өвчний улмаас 74 иргэнийг хэвтүүлэн эмчилсэн.В вирусийн сайн дурын дархлаажуулалтын 1-р тунг 1344 иргэн, 2-р тунг 519 иргэн, 3-р тунг 148 иргэн хийлгэсэн. В вирусийн дархлаажуулалтад хамрагдсан 128 иргэний дархлал тогтоцыг үзсэн. Элэг бүтэн арга хэмжээг эрчимжүүлэн, 2100 иргэнийг В, С вирус илрүүлэх оношлогоо шинжилгээнд хамруулсан.	90		

	Хөтөлбөрийн		Эхийн эндэгдлийн түвшин (100 000 амьд төрөлт тутамд)	Промиль	2024	0	0	2025 оны эхний 5 сарын статистик мэдээгээр аймгийн хэмжээнд 200 эх төрсөн. Эхийн эндэгдэлгүй байна.	100		
			Нялхсын эндэгдлийн түвшин /1,000 амьд төрөлтөд ногдох/	Промиль	2024	9.0	8.9	Аймгийн хэмжээнд 2025 оны эхний 05 сарын статистик мэдээгээр нялхсын эндэгдлийн 3 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 14.2 ногдож байгаа нь улсын дунджаас 0.7 промилээр дээгүүр байна. ЭХЭМҮТ-ийн Тандалт судалгааны албанаас “Нярайн амьсгал гачаалын хам шинж”, “Дутуу нярайн халдвар”, “Нярайн гипокси-ишемийн шалтгаант энцефалопати” сэдэвт 4 удаагийн цахим сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 42 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулж чадавхжуулсан.	90		
			5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин /1,000 амьд төрөлтөд ногдох/	Промиль	2024	21.1	21.0	Аймгийн хэмжээнд 2025 оны эхний 5 сарын байдлаар тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 6 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 29.9 байгаа нь улсын дундажтай харьцуулахад 13.2 промилээр өндөр байна. 2025 оны эхний 5 сарын байдлын тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлийн талаарх судалгаа, дүгнэлтээс үзэхэд нийт эндэгдлийн 16.6 хувь нь осол гэмтэл, 33.3 хувь нь перинаталь үеийн зарим эмгэг, 16.6 хувь нь хорт хавдар, 33.3 хувь нь амьсгалын эрхтэн тогтолцооны өвчлөлийн улмаас эндсэн байна. ЭХЭМҮТ-ийн Тандалт судалгааны албанаас зохион байгуулсан “Нярайн амьсгал гачаал хам шинж”, “Дутуу нярайн халдвар”, “Нярайн гипокси-ишемийн шалтгаант энцефалопати”, “Хүүхдийг осол гэмтлээс сэргийлье” сэдэвт 5 удаагийн цахим сургалтад 54 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд хамрагдсан.	90		
1.1.3		Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангалт, чадавхыг нэмэгдүүлнэ.	Мэргэжлийн зэрэгтэй эмч, эмнэлгийн мэргэжилтний тоо	Тоо	2024	139	144	Мэргэжлийн зэрэгтэй эмнэлгийн мэргэжилтэн нийт эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтний 26% -ийг эзэлж байна. Мэргэжлийн нийгэмлэгүүдээс 2025 оны зэрэг шинээр олгох, ахиулах шалгалтын үйл ажиллагаа зохион байгуулагдаагүй байна. Хугацаа болоогүй.	-		
			10.000 хүн амд ногдох сувилагчийн тоо	Тоо	2024	30.9	32.9	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй эрүүл мэндийн байгууллагуудад 210 сувилагч ажиллаж, 60130 хүн амд сувилахуйн тусламж үйлчилгээг үзүүлж байна. 2025 оны эхний 5 сарын байдлаар 10000 хүн амд ногдох сувилагчийн тоо 34.9 байгаа нь суурь түвшнээс нэмэгдсэн үзүүлэлттэй байна.	100		
			Нэг эмчид ногдох үйлчлүүлэгчийн тоо	Тоо	2024	585	540	Төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад нийт 115 эмч ажиллаж, хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна. Эхний 5 сарын байдлаар нэг их эмчид ногдох хүний тоо 523 байна.	100		
1.1.1.1		Эрүүл амьдралын хэв маягийг дэмжиж, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэн, хөдөөгийн хүн амд нүүдлийн амбулаторийн үйлчилгээг нэвтрүүлж, урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийн үзлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлнэ.	Сургалтад хамрагдсан иргэд	тоо	2024	14000	15000	ЭМБ-ууд 5 удаагийн нэрэмжит сарын аян, 8 тэмдэглэлт өдрүүд, 8 суманд зохион байгуулсан нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг, ерөнхий боловсролын 21 сургуульд суурилсан эрт илрүүлгийн үзлэг, оношилгоо, дархлаажуулалт зэрэг үйл ажиллагааны хүрээнд нийт 8910 иргэнийг сургалтад хамруулсан байна.	90		
			Эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалт	Хувь	2024	43.2	50	Халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгт оны эхний 5 сарын байдлаар 2807 иргэнийг хамруулж, өссөн дүнгээр үзлэгт хамрагдвал зохих нийт иргэдийн 47,4%-ийг хамруулсан нь өмнөх оны суурь түвшинтэй харьцуулахад 4.2%-иар өссөн.	90		
			Шинээр бий болсон амбулатори	тоо	2024	0	1	Нүүдлийн амбулаторын тусламж үйлчилгээ үзүүлэх бүрэн тоноглогдсон 2ш автомашины саналыг Эрүүл мэндийн сайдад хүсэлт тавьж, санал хүргүүлсэн. Хугацаа болоогүй	-		
			Зүрх судасны тогтолцооны өвчлөл	Промиль	2024	3726.7	3720.2	Зүрх судасны шалтгаант нас баралт 51 (эрэгтэй 30, эмэгтэй 21 иргэн) тохиолдол бүртгэгдсэн нь 10.000 хүн амд 8.4 промиль байна. Халдварт бус өвчлөлийн улмаас 46982 иргэн тусламж үйлчилгээ авсан. Үүнээс зүрх судасны архаг өвчний учир 9293 иргэн ЭМБ-уудад хандан амбулаториор тусламж үйлчилгээ авсан бол, шинээр зүрх судасны өвчлөл 3261 тохиолдол бүртгэгдэж, 989 иргэнг хэвтүүлэн эмчилсэн. 9646 иргэнд артерийн гипертензийн эрт илрүүлэг үзлэг хийж, 22 иргэнийг шинээр оношлон эмчийн хяналтад авсан.	90		

1.1.1.2	Хүн амын дундах зонхилон тохиолдох өвчлөлийг бууруулна.	Хоол боловсруулах тогтолцооны өвчлөл	Промиль	2024	1790.2	1789.2	“Тэнцвэртэй хооллолт”, “Эрүүл бус хүнсний хэрэглээ” сургалтыг 22 удаа зохион байгуулж, боловсролын 5 байгууллагын 187, Цагдаагийн газрын 30 албан хаагч, 16 сумын эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлсэн 222 иргэнд зохион байгуулсан. Эрүүл хооллолтын 2 төрлийн гарын авлага боловсруулан 174 иргэнд түгээсэн. Эрүүл мэндийн байгууллагуудын цахим хуудсанд 15 төрлийн постор, эрүүл зохистой хооллолт цуврал 4 видео бичлэгийг байршуулан иргэд олон нийтэд хүргэсэн. Эрүүл Монгол хүн, НЭМҮТ-өөс зарласан “САХАРГҮЙ 30 ХОНОГ CHALLENGE”-д нэгдэж, “ДОЛОО ХОНОГИЙН НЭГ ӨДРИЙГ ЧИХЭРТЭЙ” арга хэмжээний удирдамжийг боловсруулан ЭМГ-ын даргын батлуулан ЭМБ-ууд, ЕБС-уудад хүргүүлж, “Сахарын хэрэглээнээс татгалзая”, “Сахарын хэрэглээ” зэрэг 7 төрлийн постор, 3 төрлийн видео бичлэгийг хүргүүлэн иргэдэд хоол боловсруулах замын өвлөлөөс сэргийлэх мэдээлэл, мэдлэг олгосон.	90		
		Хожуу үедээ оношлогдсон хорт хавдрын өвчлөлийн эзлэх хувь	хувь	2024	49.6	44.1	Аймгийн хэмжээнд 2025 оны эхний 4 сарын байдлаар 58 хорт хавдар оношлогдон, эмчилгээнд хамрагдаад байна. Үүний 27 буюу 46.5% нь хожуу үедээ оношилогдсон байна.	90		
		Осол гэмтлийн өвчлөл	Промиль	2024	161.0	141.0	"Аюулгүй байдлын төлөө үгээ хэлцгээе" осол гэмтлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөөг батлан эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлэн, 90 хувийн биелэлттэй хэрэгжүүллээ. Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх сарын аян, түлэгдэлтийн үед үзүүлэх тусламж үйлчилгээ, ахуйн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, бага насны хүүхдийг хахалтаас сэргийлэх нь сэдэвт цуврал сургалт нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулж 447 хүнийг сургалтад хамруулж, 1859 хүнд зөвлөмж мэдээлэл түгээсэн.Аймгийн Нэгдсэн эмнэлэгтэй хамтран Цус алдалтын үед үзүүлэх анхны тусламж, гэмтлийн үеийн тээвэрлэлт, гэр бүлийн хүчирхийлэл сэдвүүдээр сургалт зохион байгуулж 9 байгууллагын 56 албан хаагчдыг хамруулсан.	90		
		Сүрьеэгийн өвчлөл	Өвчлөлийн түвшин	2024	4	4	Сүрьеэ илрүүлэх үзлэг, оношилгоог Баяннуур, Дашинчилэн, Баян-Агт, Тэшиг, Хутаг, Сэлэнгэ, Бугат, Хангал, Хялганат тосгонд зохион байгуулан 1057 хүнийг хамрууллаа. Үзлэгт хамрагдсан иргэдийн 80%-ийг рентген шилжилгээнд хамруулан, 79 иргэний гэрт очиж айлаас айлд тусламж үйлчилгээг үзүүллээ. Эрт илрүүлэг үзлэгээр 4 өвчлөл шинээр илрүүлэн, эмчилгээнд хамруусан. 2025 оны эхний 4 сарын байдлаар БЗДХ-ын тохиолдол өмнө оны мөн үетэй харьцуулахад 8 тохиолдлоор буурсан байна. Эрүүл мэндийн байгууллагууд БЗДХ, ДОХ/ХДХВ илрүүлэх түргэвчилсэн шинжилгээний нөөцийн бэлэн байдлыг бүрдүүлж хэвтэн эмчлүүлэгчид, жирэмсэн, сайн дураараа шинжилгээ өгч буй иргэд, нийт 2836 иргэнийг шинжилгээнд 13 өвчлөл илрүүлэн, эмчлэн эдгэрүүлсэн байна.	90		

1.1.2.1	Үйл ажиллагаа	Эмнэлгийн тусламж үйлчилгээнд шаардлагатай тоног, төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлж, барилга байгууламжийн их засвар, өргөтгөл, шинэчлэлийг хийж, стандартын шаардлагад нийцүүлнэ.	Барилга, байгууламжийн тоо	тоо	2024	5	5	Шинэ барилга: Сэлэнгэ сумын ЭМТ-ийн өргөтгөлийн барилгын ажлын санал 2025 оны Улсын төсвийн саналд явуулсан боловч дэмжигдээгүй. Тус саналыг дахин боловсруулан pimis.publicinvestment.gov.mn цахим хаягаар 2026 оны улсын төсвийн саналд дахин хүргүүлсэн. Зураг төсвийн 2 ажил: Аймгийн Нэгдсэн эмнэлгийн рентгений хэсэг, яаралтай тусламж, хүлээн авах, гемодиализ, эрчимт эмчилгээний тасгийн барилгын засварын ажлын зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлыг “Аслаан” ХХК гүйцэтгэж дууссан. Тус эмнэлгийн моргийн барилгын засварын ажлын зураг төсөл боловсруулах ажлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж байна. Барилгын их засварын 7 ажил: Орон нутгийн 2025 оны төсвийн санхүүжилтаар аймгийн Нэгдсэн эмнэлгийн барилгын Б блокын хэсэг 350.0 сая төгрөг, Хангал сумын ЭМТ-ийн барилгын засвар 305.0 сая төгрөг, Тэшиг сумын ЭМТ-ийн барилгын засвар 400.0 сая төгрөг, Сайхан сумын ЭМТ-ийн 2 барилгыг ариутгах татуургын төвлөрсөн шугамд холбох ажил 68.0 сая төгрөг, Могод сумын ЭМТ-ийн морго, гражийн барилгын ариутгах татуурга, цэвэр ус, цахилгаан хангамжийн ажил 104.0 сая төгрөг, Булган сумын “Эмийн цэцэглэн” ӨЭМТ-ийн дулаан, цэвэр усны шугмыг төвлөрсөн системд холбох ажил 300.0 сая төгрөг, Нэгдсэн эмнэлгийн барилга 2 барилгад лифт угсарч суурилуулах ажил 400.0 сая төгрөгийн барилгын засварын ажлууд тус тус батлагдсан. Хангал сумын ЭМТ-ийн барилгын засварын ажлын гүйцэтгэл 60%-тай, “Эмийн цэцэглэн” ӨЭМТ-ийн барилгыг төвлөрсөн инженерийн шугамд холбох ажил, аймгийн Нэгдсэн эмнэлэг, Тэшиг сумын ЭМТ-ийн барилгын засварын ажлуудын тендер шалгаруулалт үнэлгээний шатанд явж байна. Сайхан сумын ЭМТ-ийн ариутгах татуургын төвлөрсөн шугамд холбох ажил 06 сарын 02-нд эхлэнэ. Могод сумын ЭМТ-ийн морго, гражийн барилгын ариутгах татуурга, цэвэр ус, цахилгаан хангамжийн ажил 100% дууссан. Нэгдсэн эмнэлгийн 2 барилгад лифт суурилуулах ажлын гүйцэтгэгчээр “Оакс инженеринг” ХХК шалгарч угсралтын ажил 70%-тай явагдаж байна.	70		
			Нэн шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалт	хувь	2024	90.0	92.0	Аймгийн эрүүл мэндийн салбарт 2025 оны эхний хагас жилийн байдлаар тоног төхөөрөмжийн стандарт хангалт 93.2% -д хүрсэн. Үүнд: Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын 192.0 сая төгрөгийн санхүүжилтаар 16 сумын эрүүл мэндийн төвд 8 нэр төрлийн 16 ш Мобайл технологийн тоног төхөөрөмжөөр хангагдсан. Улсын төсвийн 126.0 сая төгрөгийн санхүүжилтаар хүүхдийн тусламж үйлчилгээнд шаардлагатай зүрхний цахилгаан бичлэгийн аппаратаар 17 сумын 18 эрүүл мэндийн байгууллагууд, Сайхан сумын ЭМТ-д 35.0 сая төгрөгийн ЭХО аппаратаар тус тус хангагдсан. Орон нутгийн төсвийн 160.0 сая төгрөгийн санхүүжилтаар аймгийн Нэгдсэн эмнэлэгт гемодиализын 2ш аппарат, шүдний тоног төхөөрөмж 1ш, Гурванбулаг сумын ЭМТ-д шүдний бор машин 1ш тус тус хангагдсан.	100		
			Түргэн тусламжийн автомашины парк шинэчлэлт	хувь	2024	76.2	80.0	Гурванбулаг, Бүрэгхангай, Хутаг-Өндөр, Орхон сумдын эрүүл мэндийн байгууллагуудын түргэн тусламжийн автомашины саналыг Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн. ЭМЯ-наас автомашины хангалтыг энэ оны 09 сард багтаан нийлүүлэхээр мэдэгдсэн. Хугацаа болоогүй.	-		
			Хиймэл оюун ухаан (Servicage AI)-ы оношилгоонд хамрагдсан иргэд	тоо	2024	1200	1400	Аймгийн хэмжээнд 2025 оны эхний 5 сарын байдлаар “CERVICARI AI” аппаратын умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэг үзлэгт нийт 431 эмэгтэйчүүдийг хамруулсан. Үүнээс эд, эсийн шинжилгээ өгөх шаардлагатай 118 эмэгтэйчүүдийг илрүүлж, эсийн шинжилгээнд-22, эдийн шинжилгээнд-6 эмэгтэйг хамруулсан. Эдийн шинжилгээгээр хавдрын урьдал-2 тохиолдол оношлогдож, Леер эмчилгээнд-1 эмэгтэй хамрагдсан байна.	70		

1.1.2.2	Хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаан болсон хавдрын өвчлөлийг бууруулах, урьдчилан сэргийлэх, эмчлэн эрүүлжүүлэхэд чиглэсэн "Эрүүл Булган" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	Хөтөлбөрийн хэрэгжилт	Хувь	2024	0	70	Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлын 2025 оны VI/32 дугаар тогтоолоор "Эрүүл Булган" хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна. "Эрүүл Булган" хөтөлбөрт 4 зорилтын 47 арга хэмжээг төлөвлөсөн. Шүд арга хэмжээний хүрээнд "Шүд угаалтын аварга шалгаруулах" тэмцээн зохион байгуулан, 21 сургуулийн 144 хүүхэд оролцсон. Сургалтаар эцэг эх, сурагчид, багш нарын амны хөндийн эрүүл мэндийг сахих, хамгаалах мэдлэг чадварыг нэмэгдүүлсэн. Халдварт бүс өвчний эрт илрүүлэг үзлэгт 2807 хүнийг хамруулж өссөн дүнгээр хамрагдвал зохих иргэдийн 47.4%-ийг хамруулсан өмнөх оныхоос 3.1%-иар өссөн байна.Хорт хавдар өвчнөөс сэргийлэх хүний папиллома вирусын эсрэг дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлэх 1 сарын аяныг зохион байгуулан, 16 сум, 1 тосгоны 19 ЕБС-ийн багш, 6-р ангийн суралцагчид, тэдний эцэг эхчүүд, асран харгалзагч нарын 1690 хүнийг сургалтад хамруулан, 263 хүүхдийг нөхөн дархлаажуулж, хамралт 22.4%-иар нэмэгдэж, хамрагдвал зохих хүүхдийг 63.1%-ийг хамрууллаа. Эрүүл мэндийн байгууллагууд иргэдэд эрүүл мэндийн мэдлэг олгох, зөв дадал эзэмшүүлэх, хандага өөрчлөх сургалт, сурталчилгааг тусгай хөтөлбөр, удирдамжийн дагуу зохион байгуулан 8910 хүнийг хамруулсан. Аймгийн НЭ, сум, өрхийн ЭМТ-үүд амбулаторийн үзлэгт 8899, хэвтэн эмчлүүлсэн 3822, урьдчилан сэргийлэх үзлэгт 17507, сургуульд суурилсан эрт илрүүлэг үзлэг, дархлаажуулалтад 3017, насанд хүрэгсдийн эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан 2807, нийт 33245 иргэнд эрүүл мэндийн зөвлөгөө өгч, 9068 иргэнтэй эргэх холбоотой ажилласан байна. Эрүүл мэндийн байгууллагууд иргэдийн эрүүл мэндийн мэдлэгийг нэмэгдүүлэх 212 сурталчилгаа, мэдээллийг цахим хуудсан байршуулж, цахим орчноос 42684 хүн мэдээлэл авч үзсэн байна.	70		
1.1.3.1	Эмнэлгийн мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх, давтан, гадаад, дотоодод сургах замаар эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэн, залгамж халааг бэлтгэнэ.	Сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний тоо	тоо	2024	46	12	Төрийн сангийн санхүүжилтээр төгсөлтийн дараах төрөлжсөн мэргэжлийн 2025-2026 сургалтад 6 их эмч 4 сувилагч тусгай мэргэжилтэн нийт 10 мэргэжилтэн хамрагдсан. Төвлөрлийг сааруулан нарийн мэргэшлийн тусламж үйлчилгээг орон нутагт үзүүлэх ажлын хүрээнд ХӨСҮТ-тэй хамтран хавдарын хими эмчиллгээний их эмч, хавдрын эмчилгээний эм найруулагч, сувилагч бэлтгэх богино хугацааны сургалтад 3 мэргэжилтнийг хамруулж байна.	100		
			тоо	2024	19	7	БНХАУ-д Сэргээн засах чиглэлээр 1 их эмч, БНСУ-д туршлага солилцох арга хэмжээнд 1, анхан шатны тусламжийн чиглэлээр 9 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, Тайвань улсад Чих хамар хоолойн чиглэлээр 1, БНЭУ-д Нүдний чиглэлээр 1 нийт 13 ажилтныг гадаад улсад ажлын байрны дадлага болон туршлага солилцох сургалтад хамруулсан.	100		
1.1.3.2	Эрүүл мэндийн салбарын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны нийгмийн баталгааг сайжруулж, орон нутагт ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтанд олгох дэмжлэг, урамшууллыг нэмэгдүүлнэ.	Дэмжлэг үзүүлсэн үйл ажиллагаа	тоо	2024	2	4	Эрүүл мэндийн байгууллагууд ажилтнуудаа урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, ажлын байрны таатай орчин бий болгох, эмнэлгийн мэргэжилтнүүдийг амьдрах байраар хангахад дэмжлэг үзүүлэх, гадаад, дотоодын сургалтад хамрагдахад дэмжлэг үзүүлэх зэргээр албан хаагчдаа тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжийг ханган ажиллаж байна.	70		
		Эрүүл мэндийн салбарын албан хаагч	тоо	2024	10	20	Гадаад улсад мэргэжлийн сургалтад хамрагдсан, туршлага судлах үйл ажиллагаанд оролцсон 6 албан хаагчид дэмжлэг үзүүлсэн. -Мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэх сургалтад хамрагдсан 4 ажилтанд дэмжлэг үзүүлсэн. -сумдад баригдсан төрийн албан хаагчийн орон сууцанд 3, эмнэлгийн хуучин барилгад 13, түүрээсийн байранд 1 эмнэлгийн мэргэжилтэн амьдарч байна. -Дашинчилэн суманд 2 айлын зөөврийн сууц шинээр ашиглалтад оруулсан. -1 байгууллага сувилахуйн пост, эх баригчийн өрөө, гадна доторх гэрэлтүүлэг зэргийг шинээр засварлаж ажиллах орчноо сайжруулсан байна. -Урьдчилан сэргийлэх үзлэгт нийт 309, умайн хүзүүний эрт илрүүлэгт 44, хөхний өмөнгийн эрт илрүүлэг шинжилгээнд 66 албан хаагч хамрагдаж, 1 албан хаагч хөхний момографикийн шинжилгээнд хамруулсан. В,С илрүүлэх шинжилгээ, дархлаа тогтоцын шинжилгээнд 254 ажилтан хамрагдаж, 127 албан хаагч В гепатитын сайн дурын сэргээх тун, бүрэн тун авах дархлаажуулалтад хамрагдсан.	70		

			Зарцуулсан хөрөнгө	сая төгрөг	2024	7.3	40.0	Гадаад сургалт, туршлага солилцох сургалтад хамрагдсан 6 ажилтанд 8.3 сая, дотоодын сургалтад хамрагдсан 4 ажилтанд 929.0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. 1 их эмчийн байрны түрээсийн зардалд 900.0 мянга, 3 ажилтны амьдрах байрны дулаан, цахилгааны зардалд 3.1 сая төгрөг зарцуулсан. АНЭ, Рашаант, Хялганат тосгоны ЭМТ-ийн 255 ажилтанд 326.8 сая төгрөгийн 1 сарын үндсэн цалин олгов.	70		
--	--	--	-----------------------	---------------	------	-----	------	---	----	--	--

МЭДЭЭЛЭЛ ХАРИУЦАГЧ: ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Б.ГАНТУЛГА
 УТАС: 99442404
 ИМЭЙЛ ХАЯГ: b.gantulga@bu.moh.gov.mn

[illegible]

[illegible]

[illegible]

--	--